



МОНГОЛ УЛС  
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,  
Утас: 264216, Факс: 264460,  
E-mail: info@csc.gov.mn

2020.03.16 № 01/492

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

БАЯНХОНГОР АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН  
ДАРГА Ц.ДАШЦЭРЭН ТАНАА

Зөвлөмж хүргүүлэх тухай

Төрийн албаны эрх зүйн шинэ зохицуулалтыг хэрэгжүүлэх чиглэлээр зохион байгуулж ирсэн удаа дараагийн сургалт, зөвлөгөөнд байнга хөндөж ирсэн хувьсамтгай, тодорхойгүй, төвөгтэй, эргэлзээтэй VUCA орчинд төрийн албаны шинэтгэлийн зорилтыг хэрэгжүүлж буй Та бүхэнд амжилт хүсье. Коронавируст халдварын дэгдэлтээс үүдсэн өдгөөгийн нөхцөл байдлыг дээрх орчны нэг илэрхийлэл гэж үзэж болох юм.

Тодорхой бүс нутаг, газар оронд тохиолддог байгаль, цаг уур, нийгмийн давагдашгүй хүчин зүйлийг хяналтдаа авч, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх ажлын ачаалал, ачааны хүндийг төрийн байгууллага, албан хаагчид иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын нэгдмэл хүч, оролцоотойгоор үүрэн гардаг. Энэ удаад ч Та бүхэн хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлэн ажиллаж байгаад талархалтай байна.

Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх, халдварын эрсдэлийг бууруулах ажлын явцад төрийн албаны тасралтгүй, хэвийн үйл ажиллагааг найдвартай хангаж, төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх, оновчтой, зөв зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх үүднээс Төрийн албаны зөвлөл чиг үүргийн хүрээнд зөвлөмж гарган Та бүхэнд хүргүүлж байна. Төрийн байгууллагууд өнөөгийн цаг үеийн хүндрэл бэрхшээлийг төрийн албан хаагчдын болон төрийн үйлчилгээг хүлээн авч байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад ээлтэй хандаж, амжилттай даван туулах арга зүй, гаргалгааг олоход энэхүү зөвлөмж чиглэгдсэн болно.

Гадаад улс орнуудын төрийн албаны төв байгууллага улс орондоо үүссэн онцгой нөхцөл байдалд явуулж байгаа бодлого, үйл ажиллагааг анхааралтай судалсны үндсэн дээр өөрийн орны хууль, эрх зүйн орчинд нийцүүлэн гаргасан зөвлөмжийг ажилдаа онцлог байдлаар тусган авч хэрэгжүүлэхийг хүсье.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ